



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/01

Чойбаасан

2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дэх заалт, МУЗГ-ын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого", Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/422, 2018 оны А/518 дугаар тушаал, Дорнод аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1 дэх зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн байгууллагуудын төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. Аймгийн Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. "Дорнод аймгийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр" (2016-2027 он)-ийн нэгдүгээр үе шат тайлант онд дуусахтай холбогдуулан бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд төлөвлөгөөнд дурдсан хамаарал бүхий заалтуудыг өөрийн байгууллагын 2021 оны төлөвлөлтөд гүйцэд тусган хэрэгжүүлж, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журмын хавсралтуудаар хугацаанд нь тайлагнаж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв /Д.Должин/, Уламжлалт анагаах ухааны төв /Б.Батцэцэг/, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн захирал, дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтаар асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", "Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-уудаар тус тус зохицуулж ажиллахыг Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс /Я.Эрдэнэтуяа/, Нийгмийн эрүүл мэндийн төв /Б.Сарнай/, Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Ч.Оюунтунгалаг/-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, товлосон хугацаанд холбогдох дээд шатны болон харъяа байгууллагуудад мэдээлж, гүйцэтгэл сайжруулах зөвлөмж хүргүүлэн ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн /Б.Гантуяа/-д даалгасугай.

ДАРГА



Ч.ОЮУНАА

Эрүүл мэндийн газрын даргын.....оны
 01...сарын...11...ны/ний өдрийн...1101
 дугаар/дүгээр тушаалын
 хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах Нэгж, хамтран ажиллах байгууллага
Стратеги төлөвлөгөөний зорилго 1:“Ковид-19” цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
Зорилт 1.1:“Ковид-19” цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж, эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангана. Зорилтот түвшин: “Ковид-19” цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа сайжирч, урьдчилан сэргийлэх ухуулга, нөлөөллийн ажлын тоо, хувь нэмэгдэнэ.							
1.1.1.	“Ковид-19” халдварт цар тахлын үед аж ахуй нэгж, хувираа хөдөлмөр эрхлэгчдэд ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангах, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тасралтгүй зохион байгуулна.	Зохион байгуулалтын	Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо	78	50 80	Улирал тутамд	Нийгмийн эрүүл мэндийн төв, анхан шатны ЭМБ
			Мэдээлэл, сурталчилгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	70	10 50		
			Мэдээлэл, сурталчилгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	28730	13000 29000		
Зорилт 1.2:“Ковид-19” цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ. Зорилтот түвшин 1.2:“Ковид-19” цар тахлын үеийн төсвийн санхүүжилт нэмэгдсэн байна.							
1.2.1.	Цахим суваг ашиглан “Ковид-19” шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэхэд	Зохион байгуулалтын	Хамтран ажилласан байгууллагын тоо	4	5 5	Улирал тутамд	Нийгмийн эрүүл мэндийн төв,